



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 01 сарын 25 өдөр

Дугаар А/14


Хужирт сум

Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн
бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацаанд
авах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 "б", Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8 дахь заалт, аймгийн Засаг даргын 2021 оны "Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацаанд авах зарим арга хэмжээний тухай А/21 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улаанбаатар хотоос сумын харъяалалтай иргэдийг татан авах ажлыг 2021 оны 01 дүгээр сарын 22-ны өдрөөс 01 дүгээр сарын 27-ны өдрүүдэд зохион байгуулж, Халдвартай бүсээс ирсэн иргэдийг гэрийн хязгаарлалтад 14 хоног байлгах, уг хугацаанд халдвар хамгааллын дэглэмийг мөрдүүлэх, 60 хоногийн хугацаанд Улаанбаатар хот руу буцах хөдөлгөөн хийлгэхгүй байхад хяналт тавьж ажиллахыг Сумын Эрэн хайх, аврах бүлгийн дарга, ажиллагааны зааварчлагч Д.Баянсан, Цагдаагийн тасгийн дарга, дэд хурандаа (Х.Түмэнбаяр), Эрүүл мэндийн төвийн эрхлэгч (Ц.Ундрахбаяр), Засаг даргын Тамгын газрын дарга (З.Цэцэгмаа), багийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.
2. Сумын хойд талын Шунхлай уулзварын байнгын хяналтын цэгийг 2021 оны 01 дүгээр сарын 25-ны өдрөөс эхлэн ажиллуулсугай.
3. Гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэргийг бууруулсантай холбогдуулан 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрөөс эхлэн архи, согтууруулах ундаа худалдах, түүгэр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй цэгүүдэд 18 хувиас дээших спиртийн агууламжтай архи, согтууруулах ундаа худалдаалахыг зөвшөөрсүгэй.
4. Захирамжийг хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Онцгой комиссын орлогч дарга (Б.Дэмбэрэл), Цагдаагийн тасгийн дарга, дэд хурандаа (Х.Түмэнбаяр) нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ

250100027